

ЯАРАЛТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОХУ-ЫН ЭМЧ НАР ДАРАМТ, ХАВЧЛАГАД ӨРТСӨӨР БАЙНА

ОХУ-ын өмнөд хэсэгт Калач-на-Дону хотын эмнэлэгт ажиллаж байсан эмч Татьяна Ревва “Ковид-19” цар тахалтай холбоотой хувийн хамгаалах хэрэгслийн хомсдол ба бусад асуудлыг илчилснийхээ төлөө шийтгэл хүлээсэн хэвээр байна. Тэрээр сахилгын шийтгэл оногдуулсан эмнэлгийн эсрэг гаргасан иргэний нэхэмжлэлийг нь 7-р сарын 23-нд хүлээж авахаас татгалзсан шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалджээ. Татьяна мөн эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй байгаагаа 7-р сард мэдсэн юм. Дүүргийн прокурорын газраас түүний эсрэг, ялангуяа гаргасан өргөдөл гомдолтой нь холбоотойгоор гүтгэлгийн хэрэг үүсгэхгүй байх шийдвэрийг цуцалсан байна.

ТА ДАРААХЬ ЗАХИДЛЫН ЗАГВАР АШИГЛАН, ЭСВЭЛ ӨӨРИЙН ҮГЭЭР ЗАХИДАЛ БИЧНЭ ҮҮ.

Волгоград Мужийн Прокурор

Денис Алексеевич Костенко

Волгоград Мужийн Прокурорын Газар

УЛ. Историческая, 124, Волгоград, 400075, ОХУ

Факс: +7 8442 310 388

Цахим хаяг: volgoprocc@volgoprocc.ru ба smi@34.mailop.ru

Онлайн маягт (орос хэл дээр): https://epp.genproc.gov.ru/web/proc_34/internet-reception/personal-receptionrequest

Хүндэт Волгоград Мужийн Прокурор оо,

Калач-на-Дону хотын эрчимт эмчилгээний тасгийн эмч Татьяна Ревва Ковид-19 цар тахлын хүрээнд эмнэлгийн ажилтнуудад зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл хомсдолтой байгаа талаар эмнэлгийн захиргаанд удаа дараа гомдол мэдүүлсэн ч, харин эргээд түүнд сахилгын шийтгэл оногдуулжээ. Татьяна Ревва гомдол гаргасныхаа төлөө үндэслэлгүйгээр сахилгын шийтгэл хүлээж, зөвхөн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, санаа тавьсныхаа төлөө ажлаасаа халагдаж болзошгүй байна. Тэрээр Ковид-19-ийн тархалттай тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авч, эрүүл мэндийн боломжит хамгийн дээд стандартыг хангаж ажиллахыг хичээж ирсэн. Түүнд сахилгын шийтгэл оногдуулсан эмнэлгийн эсрэг гаргасан иргэний нэхэмжлэлийг нь 7-р сарын 23-нд шүүх хэрэгсэхгүй болгосныг сонсоод би маш их цочирдлоо. Татьяна энэ шийдвэрийг давж заалдаж байгаа.

Татьяна Ревва түүний гаргасан гомдлын зарим асуудлыг мужийн прокурорын газраас явуулсан эмнэлгийн хяналт шалгалтаар баталгаажуулсан тухай албан бичгийг танай байгууллагаас 7-р сард хүлээж авсан. Гэвч түүнд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 128.1-р зүйл("Гүтгэлэг")-д заасан эрүүгийн хэрэг үүсгэхгүй байх тухай дүүргийн цагдаагийн газрын шийдвэрийг Калачевский дүүргийн прокурорын газар хүчингүй болгосон хэмээн тус бичигт мөн дурджээ. Үүнд Татьянад эрүүгийн хэрэг үүсгэх эсэх талаар нэмэлт мөрдөн байцаалтын өмнөх шалгалт хийхийг цагдаагийн байгууллагад үүрэг болгосныг дурдсан байна. Мөрдөн байцаалтын өмнөх шатны хяналт шалгалтыг Татьяна Реввагийн ажиллаж байсан эмнэлгийн ерөнхий эмчийн гаргасан гомдлын дагуу явуулсан ба тухайн үед цагдаа нар үндэслэлтэй нотолгоо олоогүй тул эрүүгийн хэрэг үүсгэхээс хэд хэдэн удаа татгалзсан байдаг.

Би танаас Татьянаг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж, дарамт шахалтгүйгээр мэргэжлийн үүргээ гүйцэтгэх боломжийг нь баталгаажуулан, түүний эсрэг явуулж буй хариу үйлдлийг зогсоох бүх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хүсэж байна. Мөн Калач-на-Дону хотын эмнэлэг болон Волгоград мужийн бусад эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнууд Ковид-19-ийн цар тахлаас хангалттай хамгаалагдаж байгаа эсэхийг баталгаажуулахыг би уриалж байна.

Гүнээ хүндэтгэсэн,



НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

ОХУ-д эрүүл мэндийн ажилтнууд, иргэний нийгмийн идэвхтэн, хүний эрх хамгаалагчид Ковид-19 цар тахлын үеэр гүтгэлэг, хэлмэгдүүлэлттэй нүүр тулж байгаа талаарх мэдээлэл тасрахгүй байна. Зарим идэвхтэн, шүгэл үлээгчид шаардлагатай тоног төхөөрөмж хомсдолтой, бэлтгэл, сургалт байхгүй, цалин бага, хөдөлмөрийн аюулгүй нөхцөл байдал хангагдахгүй байгаа талаар санаа зовниж байгаагаа илэрхийснийхээ төлөө мөрдөн шалгагдаж байна.

Гуравдугаар сарын эхээр Татьяна Ревва санаа зовж буй асуудлаа бие даасан үйлдвэрчний эвлэл болох "Эмч нарын холбоо"-нд мэдэгдэж, эмнэлгийн ажилчдад тулгарч буй асуудлыг хөндсөн видео бичлэг хийжээ. Үйлдвэрчний эвлэлд бичсэн түүний захидал, бичлэг олон нийтэд ил болсны дараахан эмнэлгийн удирдлагууд түүний нэхэмжлэл үндэслэлгүй хэмээн шүүмжлэлийнх нь төлөө Татьяна Реввад сахилгын арга хэмжээ авчээ. Түүний өгүүлснээр нэг сарын дотор эмнэлгийн захиргаанаас албан ёсоор хоёр удаа сануулга өгч, нэг удаа бичгээр мэдэгдэл өгсөн бөгөөд зургаан удаа ажилдаа гаргасан зөрчлийнхөө талаар тайлбар бичиж өгөх шаардлагатай болсон аж. Татьяна Реввад оногдуулсан сахилгын шийтгэлийн нэг нь өвчтөний нууц задруулахыг завдсан хэрэг байсан бөгөөд тэрхүү өвчтөн зүрхний шигдээсээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан аав нь юм. Татьянаг аав дээрээ очиж уулзахад нь өвчтөний бүртгэлийн хуудас бөглөсөн байх ёстой гэсэн үндэслэлээр албан ёсоор шийтгэл ногдуулжээ. Тэрээр гэр бүлийнхээ гишүүний хувиар эргэж байсан бөгөөд эцгийнхээ зөвлөх эмч биш гэдгээ мэдэгдсэн байна. Үүгээр ч зогсохгүй эцгийнх нь өвчин түүний мэргэжлийн хүрээнд ч хамааралгүй байсан тул энэ тохиолдолд Татьяна өвчтөний бүртгэлтэй ямар ч холбоогүй байв. Тэрээр үйлдвэрчний эвлэлд илгээсэн захидал, сэтгүүлчтэй хийсэн ярилцлагадаа энэ үйл явдлын талаар дурдсан байдаг. Татьяна эцгийнхээ хувийн мэдээлэл, оношийг задруулаагүй тул өвчтөний нууцлалыг зөрчөөгүй. Гэсэн хэдий ч энэ нь түүнд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болж, ажлаасаа халагдахад хүргэж болзошгүй байгаа юм.

Олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүний дотор бүх төрлийн мэдээлэл хүлээн авах, хайх, түгээх эрхийг засгийн газар хамгаалах үүрэгтэй. Нийгмийн эрүүл мэндтэй холбоотойгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж болох ч үүнийг хуулиар тодорхой заасан, зайлшгүй, тохирохуйц, ялгаварлан гадуурхаагүй байх ёстой. Эрх баригчид эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл олж авах, түгээх явдлыг хязгаарлаж болохгүй бөгөөд хүмүүст хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээр дамжуулан мэдээлэл авах, өөрсдийгөө хамгаалах, засгийн газраас авч хэрэгжүүлж буй эрүүл мэндийн арга хэмжээг дагаж мөрдөхөд зайлшгүй шаардлагатай албан ёсны мэдээлэл, баримт бичигт нэвтрэх боломжтой байхыг нь баталгаажуулах ёстой.

Сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллага, идэвхтнүүд, эрүүл мэндийн ажилтнууд болон мэдээлэл түгээх зорилготой бусад хүн бүрт цензур тогтоон, тэднийг айлган сүрдүүлэх, хариу арга хэмжээ авах болон сахилгын шийтгэл ногдуулахаас аливаа улс татгалзах ёстой. Улс орон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүмүүсийн мэдээлэл хайх боломжийг хязгаарласнаар хүний эрхийг хангах үүргээ зөрчихөөс гадна нийгмийн эрүүл мэндийн төлөөх үйл ажиллагааныхаа үр нөлөөг алдагдуулахад хүрнэ. Нэмэлт мэдээллийг дараахь линкээр орж үзнэ үү.

<https://www.amnesty.org/en/documents/eur01/2215/2020/en/>

Ковид-19-ийн эсрэг арга хэмжээ авахдаа аливаа улс мэдээллийг хязгаарлан, ил тод биш, цензур тогтоодог бол дээр дурдсан хүний эрхийг дордуулах эрсдэлтэй. (дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү: <https://www.amnesty.org/en/documents/pol30/1967/2020/en/>) Түүнчлэн хүмүүс өөрсдийгөө халдвараас хамгаалах шаардлагатай арга хэмжээ авах, бодит дүр зургийг олж харан, вирусын тархалттай тэмцэх үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад нь бэрхшээл учруулж болзошгүй юм. Эрүүл мэндийн ажилтнууд өөрсдөд нь болон гэр бүлд нь учирч болзошгүй эрсдэлийг үл харгалзан үйлчилгээгээ үзүүлж, энэхүү цар тахалтай тэмцэх ажлын тэргүүн шугамд ажилласаар байна. Ажлынхаа хажуугаар Ковид-19-тэй тэмцэхэд илүү цагаар ажиллах, сэтгэл түгших, ядрах, сульдах зэрэг эрсдэлтэй тулгарч байна.

ОХУ-д Ковид-19-ийн халдвар авсан, нас барсан эмнэлгийн ажилчдын талаарх албан ёсны статистик тоо байхгүй ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон зуун эрүүл мэндийн ажилтнууд тус улсад халдвар авсан байгааг дурдсан бөгөөд албан бус вэб сайтын мэдээллээр (<https://sites.google.com/view/covid-memory/home>) цар тахлын эсрэг тэмцэж нас барсан 600 гаруй эмнэлгийн ажилчдын жагсаалтыг гаргажээ. Маш олон эмнэлгийн ажилтан, мэргэжилтнүүд хувийн хамгаалалтын хэрэгсэл хүртээмжгүй хийгээд ажлын нөхцөл, цалин хөлс хангалтгүй байгаа талаар гомдол гаргасаар байна.

ТА ЗАХИДЛАА ОРОС, АНГЛИ ХЭЛЭЭР БИЧНЭ ҮҮ.

Мөн та өөрийн орны хэлээр бичиж болно.

ЯАРАЛТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭН ДАРУЙ ЭХЛҮҮЛЭЖ, 2020 ОНЫ 10-Р САРЫН 14 ХҮРТЭЛ ЯВУУЛАХ БОЛОМЖТОЙ

Хугацаа дууссаны дараа захидал, өргөдөл илгээхийг хүсвэл өөрийн улсын Эмнести Интернэшнлд хандаарай.

НЭР, ТӨЛӨӨНИЙ НЭР: Татьяна Ревва (тэр/эмэгтэй)

Өмнө нь авсан арга хэмжээний холбоос: <https://www.amnesty.org/en/documents/eur46/2301/2020/en/>